



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

20 22 он 03
сарын 04 өдөр

Дугаар 31-1/35

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР ТАНАА

Хуулийн төсөл өргөн
мэдүүлэх тухай

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгөхийг хүсье.

Монгол Улсын Ерөнхий сайд

Л.ОЮУН-ЭРДЭНЭ



000021405062



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20... он ... дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 137/2012

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Л.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товлох тухай

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр холбогдох материалыг хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга

Ц.НЯМДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭС**

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдааны 3 дугаар тэмдэглэлд:

“III.ХЭЛЭЛЦСЭН нь:

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,

Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 75 33,

Цахим шуудан: info@mojha.gov.mn,

Цахим хуудас: www.mojha.gov.mn

2022.01.27 № 11470

таний 2022.01.19 -ны № 1а /153 -т

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД Г.САЙХАНБАЯР ТАНАА

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсгийг үндэслэн Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



15160-1939
А5 файл 2022



БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД
Г.САЙХАНБАЯР ТАНАА

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26 74 68, И-мэйл:info@mof.gov.mn
Вэбсайт:www.mof.gov.mn

2022. 01. 25 № 4-3 / 341
танай 2022. 01. 19 -ны № 1а / 152 -т


Г

Г

Хариу хүргүүлэх тухай

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын хуралдаанаар хэлэлцүүлэхтэй холбогдуулан зөвшөөрөл авахаар ирүүлсэн Таны албан бичигтэй танилцлаа.

Хуулийн төсөл батлагдсанаар 2022 оны батлагдсан төсөвт нэмэлт ачаалал үүсгэхгүй, цаашид төсвийн дунд хугацаанд зардал буурах эерэг нөлөөтэй байх тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7-д заасны дагуу Улсын Их Хурлын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрөл олгож байна.



Б.ЖАВХЛАН

9762000462



ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН
ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага:

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль нь 1994 онд батлагдсан ба зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, тагнуул, төрийн тусгай хамгаалалт, цагдаа, шүүхийн шинжилгээний болон авлигатай тэмцэх, онцгой байдлын асуудал эрхэлсэн болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын генерал, офицер, ахлагч, түрүүч, байлдагч, цэрэг, цагдаагийн сургуулийн сонсогч /энэ хуульд цаашид "цэргийн алба хааг" гэх/ нарт тэтгэвэр, тэтгэмж тогтоож, олгохтой холбоотой олон салбарын алба хаагчдын нийгмийн хамгаалал, эрх зүйн байдалтай холбогдох харилцааг зохицуулах хууль болохын хувьд цаг үеийн шаардлагаар нийт 23 удаа нэмэлт, өөрчлөлт орсон байна.

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн хэрэгцээ, шаардлагыг Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын /цаашид Аргачлал гэх/ 1.3-т заасан хүрээнд хамаarahгүй тул урьдчилан тандан судлах ажиллагааг Аргачлалын 2.1-т заасан үе шатны дагуу гүйцэтгэж, тус хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсрууллаа.

1.1.Хууль зүйн үндэслэл, шаардлага:

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 12 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"-д батлан хамгаалах чиглэлээр Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар тусгагдаж, цэргийн тэтгэвэр авагч нас барсан тохиолдолд түүний ар гэрт оршуулгын тэтгэмж олгохтой холбоотой эрх зүйн зохицуулалтыг тусгахаар заасан.

Мөн Улсын Их Хурлын Хүний эрхийн дэд хорооны 2021 оны 02 дугаар тогтоолд цэргийн албаны үйл ажиллагаанд баримталдаг батлан хамгаалах салбарын хууль тогтоомжуудад хяналт шинжилгээ, хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх талаар тусгасан. Тогтоолын хэрэгжилтийг хангах арга хэмжээний хүрээнд Батлан хамгаалах яам нь Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хоёр талын гэрээг байгуулж Батлан хамгаалах тухай, Зэвсэгт хүчний тухай, Цэргийн албаны тухай, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиудад хяналт шинжилгээ, хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийлгэсэн болно. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд хийсэн хяналт шинжилгээ, хэрэгжилтийн үр дагавар дахь үнэлгээний зөвлөмжид хуульд өөрчлөлт оруулах замаар тус хуулийн зарим эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар заажээ.

Улсын Их Хурлын 2015 оны 85 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичигт 5.6 дахь хэсэгт “Цэргийн алба хаагч, цэргийн анги, байгууллагад гэрээгээр ажиллагсдын алба хаах нөхцөлийг бүрдүүлэх, нийгмийн баталгааг хангах эрх зүйн орчныг боловсронгуй болгоно” гэж, Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3-т “цэргийн алба хаагчийн нийгмийн хамгаалал, эрх зүйн байдлыг албаны онцлогт нь тохируулж тогтоох” гэж, мөн хуулийн 15 дугаар зүйлийн 15.3.4-т “батлан хамгаалахын хүний нөөцийн бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэх, цэргийн алба хаагч, түүний гэр бүл, бэлтгэл болон чөлөөнд байгаа офицер, ахлагчийн нийгмийн хамгаалал, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах” гэж тус тус заасантай нийцүүлэн Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах эрх зүйн хэрэгцээ, шаардлага тодорхойлогдож байна.

1.2.Практик үндэслэл, шаардлага:

Цэргийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.4, 11.5 дахь хэсэгт заасан цэргийн алба хаах хугацаатай холбогдох эрх зүйн зохицуулалтын дагуу эмэгтэй цэргийн алба хаагч нь Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгох эрх зүйн үндэслэл бүрдэх ба тус хуулийн хэрэгжилтийн талаар хийсэн дүн шинжилгээ болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай ажил хэргийн шугамаар тухайн асуудлаар санал солилцоход хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар асуудлыг шийдвэрлэх нь оновчтой гэж үзсэн болно.

Тодруулбал, тус хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах төрийн цэргийн болон бусад байгууллагын алба хаагч нь Цэргийн албаны тухай хуульд заасны дагуу ахлагчийн албыг 47 нас хүртэл, офицерын албыг цолны ангиллын дагуу дунд офицер 47 нас хүртэл, ахлах офицер 52 нас хүртэл, дээд офицер 57 нас хүртэл хаахаар заасан ба эмэгтэйчүүд офицерын албыг цэргийн цол харгалзахгүйгээр 47 нас хүртэл хаах эрх зүйн зохицуулалт үйлчилж байгаа бол Цагдаагийн албаны тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт цагдаагийн алба хаагчийн насын дээд хязгаар нь цагдаагийн бага цолтой алба хаагч 47 нас, цагдаагийн дунд цолтой алба хаагч 52 нас, цагдаагийн ахлах цолтой алба хаагч 55 нас, цагдаагийн дээд цолтой алба хаагч 57 нас, эмэгтэйчүүд цагдаагийн албыг цол харгалзахгүйгээр 47 нас хүртэл хаахаар заажээ.

Эмэгтэй цэргийн алба хаагч ахлагч болон офицерын албыг цэргийн цол харгалзахгүйгээр дунджаар 47 нас хүртэл хаахаар Цэргийн албаны болон Цагдаагийн албаны тухай хуульд нийтлэг байдлаар хуульчилсантай холбогдуулан эмэгтэй цэргийн алба хаагчийн хувьд жирэмсэн болон хүүхэд асрах чөлөөтэй байх хугацааг цэргийн алба хаасан хугацаанд оруулан тооцох талаар эрх зүйн зохицуулалт хангалтгүй байгааг хуульд нарийвчлан тусгах хэрэгцээ шаардлага байгаа болно.

Мөн тус хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын алба хаагч нь 47-57 насын хооронд цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгож, Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт заасан 60, түүнээс дээш настай эрэгтэй, 55 түүнээс дээш настай эмэгтэйд хамаарах насын шаардлагад хамаардаггүйгээс шалтгаалан ахмад настны дэмжлэг, туслалцаанаас гадуур орхигдож байна.

Тодруулбал, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дахь хэсэгт “Цэргийн алба хаагч, түүнчлэн дайчилгаатай сургууль цугларалтад оролцож байгаа цэргийн үүрэгтэн нас барагчад түүний оршуулгад зориулан нас барагчийн ар гэрт олгох тэтгэмж олгоно.” гэж заасан ба харин цэргийн тэтгэвэр тогтоолгосон иргэн насын хувьд Ахмад настны тухай хуулийн үйлчлэлд хамаарахгүй байгаагаас нас барсан тохиолдолд түүнд нийгмийн халамжаас оршуулгын тэтгэмжийг олгогдохгүй байгаа нь энэ төрлийн эрх зүйн зохицуулалтгүй байгаатай шууд холбоотой юм.

Түүнчлэн хүчин төгөлдөр мөрдөж байгаа Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар цэргийн алба хаагч 10-аас доoshгүй жил цэргийн алба хаагаад орон тоо, зохион байгуулалтын өөрчлөлт, биеийн эрүүл мэндээр, түүнчлэн цэргийн алба хаах нас хэтэрч халагдсан тохиолдолд хувь тэнцүүлэн тэтгэвэр авах эрх үүсэхээр хуульчилсан боловч тус хуулийн нэг удаагийн тэтгэмж олгохтой холбогдох 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Цэргийн алба хаагч орон тоо, зохион байгуулалтын өөрчлөлт, биеийн эрүүл мэндээр, түүнчлэн цэргийн алба хаах нас хэтэрч халагдвал түүнд 18 сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний тэтгэмжийг нэг удаа олгоно.” гэж заасны дагуу цэргийн алба хаагч 10-аас доош жил ажиллаад хуулийн 19 дүгээр зүйлд заасан үндэслэлээр цэргийн албанаас халагдах тохиолдолд жил хамаарахгүйгээр нэг удаагийн хувь тэнцүүлсэн тэтгэмж авахаар ойлгогдож байх тул энэхүү эрх зүйн зохицуулалтыг нэг мөр ойлгож, хэрэглэх боломжийг бүрдүүлэх ажлын хүрээнд нэг удаагийн тэтгэмж олгохтой холбогдсон харилцааг хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэгтэй уялдуулан нарийвчлан тодорхойлох шаардлага байгаа болно.

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хууль зүйн судалгааны төвөөс хийгдсэн судалгааны тайлангаас гарсан зөвлөмжөөр тус хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох практик хэрэгцээ, шаардлага байгаа болно.

Иймд дээрх хууль зүйн болон практик хэрэгцээ шаардлагад нийцүүлэн Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох үүднээс хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсрууллаа.

Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээний талаар:

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслээр цэргийн тэтгэвэр тогтоолгосон иргэн нас барсан тохиолдолд оршуулгын тэтгэмж авах, эмэгтэй цэргийн алба хаагчийн хувьд жирэмсний болон хүүхэд асрах чөлөөтэй байх хугацааг цэргийн алба хаасан хугацаанд оруулан тооцох, тус хуулийн 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан хувь тэнцүүлэн тэтгэвэр тогтоолгоход нэг удаагийн тэтгэмж олгохтой холбогдсон харилцааг хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэгтэй уялдуулан нарийвчлан тодорхойлох, хуулийг нэг мөр ойлгож, хэрэглэх боломжийг бүрдүүлэх ажлын хүрээнд батлан мөрдөж байгаа зарим аргачлалын эрх зүйн үндэслэлийг хуульчлах зэрэг эрх зүйн зохицуулалтуудыг тусгана.

Мөн Хууль тогтоомжийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэгт заасны дагуу Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн хэрэгжилтийн үр

дагаварт Хууль зүйн үндэсний хүрээлэнгээр хийлгэсэн судалгааны үр дүнд үндэслэн хуулийн зарим нэр томьёог өөрчлөх, нэг мөр ойлгож хэрэглэх боломжийг хуулийн төсөлд тусгах юм. Тухайлбал:

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийг “халагдсан бол” гэснийг “чөлөөлөгдсөн бол” гэж, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн “халагдах тохиолдолд” гэснийг “чөлөөлөгдсөн тохиолдолд” гэж, 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэг “халагдвал” гэснийг “чөлөөлөгдвэл” гэж тус тус өөрчлөх шаардлагатай байгаа юм.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх саналын талаар:

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагын алба хаагчдын эрх зүйн байдал, нийгмийн баталгаа сайжирч, хууль тогтоомжийг нэг мөр ойлгож хэрэглэх боломж нэмэгдэх зэрэг олон давуу тал бий болж, хууль эрх зүйн орчин боловсронгуй болно.

Тус хуулийг баталснаар нийгэм, эдийн засаг, хууль зүйн сөрөг үр дагавар үүсэхгүй бөгөөд улсын төсвөөс нэмэлт зардал гарагчийг.

Дөрөв.Хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар:

Уг хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон батлан хамгаалахын хууль тогтоомжтой нийцэж байгаа бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах бусад хууль тогтоомжууд байхгүй болно.

-оОо-

ТАНИЛЦУУЛГА

/Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн талаар/

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль нь 1994 онд батлагдаж, нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, шинээр болон шинэчлэгдэн батлагдсан хууль тогтоомжтой нийцүүлэх асуудлын хүрээнд нийт 23 удаа нэмэлт, өөрчлөлт орсон байна.

Хуулийн төслийг боловсруулах эрх зүйн үндэслэл нь Монгол Улсын Их Хурлын 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д батлан хамгаалах чиглэлээр Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар тусгагдаж, эмэгтэй цэргийн алба хаагчийн жирэмсний болон хүүхэд харах чөлөөтэй байх үеийн хугацааг нарийвчлан тогтоох болон цэргийн тэтгэвэр тогтоолгосон иргэн нас барсан тохиолдолд түүний ар гэрт оршуулгын зардал олгохтой холбоотой зарим эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар тусгасан.

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын эмэгтэй алба хаагч нарын жирэмсний болон хүүхэд харах чөлөөтэй байх хугацааны эрүүл мэндийг даатгалын шимтгэлийн төлбөл зохих хэмжээг ажил олгогч буюу төрийн байгууллага хэрхэн төлөхтэй холбогдсон эрх зүйн зохицуулалт байхгүйгээс дээрх хугацаанд алба хаагчийн ажилласан жил болон цэргийн алба хаасан хугацааг хэрхэн тооцох асуудлыг шийдвэрлэх хэрэгцээ шаардлага үүсээд байна.

Зөвхөн Зэвсэгт хүчний хэмжээнд дээрх эрх зүйн зохицуулалт тодорхой бус байдлаас цэргийн нэгтгэл, анги, салбарууд өөр өөрийн төсөвтэй уялдуулан /ихэвчлэн цолны мөнгөөр/ ажилласан жилийг тодорхойлохдоо өөрийн төсөвт тодорхой хэмжээний зохицуулалт хийж иржээ. Тухайлбал, 2020 онд жирэмсний болон хүүхэд харах чөлөөтэй шалтгаантай /давхардсан тоогоор/ нийт 2183 эмэгтэй цэргийн алба хаагчид 326 694 339 төгрөг, 2021 онд мөн үндэслэлээр 2378 эмэгтэй цэргийн алба хаагчид 353 221 167 төгрөгийг олгож, энэ хэмжээгээр эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлжээ.

Иймд энэхүү хуулийн төслөөр Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасантай нийцүүлэн цэргийн алба хаагч эмэгтэйн жирэмсний болон амаржсаны амралттай байх хугацаа, хүүхэд асрах чөлөөтэй байх хугацааны төлбөл зохих эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг Хөдөлмөр нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хорооноос тухайн үед мөрдүүлэхээр баталсан сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцон сар бүр улсын төсвөөс хариуцан төлөх эрх зүйн зохицуулалтыг хуульд тусгаснаар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 420 000 төгрөгөөр тооцон эрүүл мэндийн мэндийн даатгалын нэг сард төлөх дүнг дунжаар 8400 төгрөгөөр бодож, сард 229 хүнээр тооцоход жилд төлөх мөнгөн дүн нь 23 083 200 төгрөг болох юм.

Мөн Цэргийн албаны болон Цагдаагийн албаны тухай хууль тогтоомжид эмэгтэй алба хаагч ахлагч болон офицерын албыг цэргийн цол харгалзахгүйгээр дунджаар 47 нас хүртэл хаахаар нийтлэг байдлаар хуульчилсантай холбогдуулан эмэгтэй алба хаагчийн жирэмсний болон хүүхэд асрах чөлөөтэй байсан хугацааг

цэргийн алба хаасан хугацаанд оруулан тооцохтой холбогдсон эрх зүйн зохицуулалтыг хуулийн төсөлд тусгана.

Түүнчлэн цэргийн алба хаагч цэргийн алба хаах хугацаандаа нийгмийн даатгалын шимтгэл цалин хөлснөөс төлдөггүй эрх зүйн зохицуулалттай холбоотойгоор цэргийн тэтгэвэр тогтоолгоод Ахмад настны тухай хуулийн насанд хүрээгүй байхдаа нас барсан тохиолдолд түүнд оршуулгын зардал олгогдоггүй хуулийн хийдэл байгааг засаж, тус хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт энэ талаарх зохицуулалтыг нэмж тусгах шаардлага байгаа болно.

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу цэргийн алба хаагч 10-аас доошгүй жил цэргийн алба хаагаад орон тоо, зохион байгуулалтын өөрчлөлт, биеийн эрүүл мэндээр, түүнчлэн цэргийн алба хаах нас хэтэрч халагдсан тохиолдолд хувь тэнцүүлэн тэтгэвэр авах эрх үүсэхээр хуульчилсан боловч тус хуулийн нэг удаагийн тэтгэмж олгохтой холбогдох 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Цэргийн алба хаагч орон тоо, зохион байгуулалтын өөрчлөлт, биеийн эрүүл мэндээр, түүнчлэн цэргийн алба хаах нас хэтэрч халагдвал түүнд 18 сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний тэтгэмжийг нэг удаа олгоно.” гэж тусгасантай холбогдуулан дээрх үндэслэлээр чөлөөлөгдсөн цэргийн алба хаагч нэг удаагийн тэтгэмж авахаар ойлгогдож байгаа нь Хөдөлмөрийн тухай хууль болон Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авах тухай хуулийн бусад зохицуулалттай давхардуулан тэтгэмж авахаар байгааг өөрчилж, нэг удаагийн тэтгэмж олгохтой холбогдсон харилцааг хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэгтэй уялдуулан нарийвчлан тодорхойлох шаардлага байгаа болно.

Хуулийн төслийг боловсруулахдаа Хууль тогтоомжийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу төрийн захиргааны төв байгууллагууд болон Зэвсэгт хүчний Жанжин штаб, төрийн бус байгууллагуудаас саналыг авахад дэмжсэн бөгөөд хуулийн төслийн хэлэлцүүлгийг Зэвсэгт хүчний удирдах бүрэлдэхүүний стратегийн цугларалт дээр явуулж, Батлан хамгаалах яамны албан ёсны цахим сайтад иргэдээс санал дүгнэлт авахаар хуулийн төслийг байршуулсан бөгөөд санал ирээгүй болно.

Иймд дээрх хууль зүйн болон практик хэрэгцээ шаардлагад нийцүүлэн Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, хуулийн зарим эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох үүднээс хуулийн төслийг боловсрууллаа.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг нэмсүгэй:

1/17¹ дүгээр зүйлийн 4 дахь хэсэг:

“4. Эмэгтэй цэргийн алба хаагчийн жирэмсний болон хүүхэд асрах чөлөөтэй байсан хугацааг цэргийн алба хаасан хугацаанд оруулан тооцно.”

2/17¹ дүгээр зүйлийн 5 дахь хэсэг:

“5. Цэргийн алба хаагч эмэгтэйн жирэмсний болон амаржсаны амралттай байх хугацаа, хүүхэд асрах чөлөөтэй байх хугацааны төлбөл зохих эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг Хөдөлмөр нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хорооноос тухайн үед мөрдүүлэхээр баталсан сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцон сар бүр улсын төсвөөс хариуцан төлөх ба шимтгэл төлөлтийг тухайн алба хаагчийн анги, байгууллага нь нийгмийн даатгалын байгууллагад тайлагнана.”

3/24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг:

“2. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг хэрэгжилтийг хангахтай холбогдсон зааврыг батлан хамгаалах болон нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.”

2 дугаар зүйл. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай 20 дугаар зүйлийн 1 дахь хэсгийн “Цэргийн алба хаагч, түүнчлэн дайчилгааны сургууль, цугларалтад оролцож байгаа цэргийн үүрэгтэн” гэсний дараа “цэргийн тэтгэвэр авагч” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“2. Цэргийн албыг 10-аас доошгүй жил хаасан цэргийн алба хаагч орон тоо, зохион байгуулалтын өөрчлөлт, биеийн эрүүл мэндээр, түүнчлэн цэргийн алба хаах нас хэтэрч ажлаас чөлөөлөгдвэл түүнд 18 сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний тэтгэмжийг нэг удаа олгоно.”

4 дүгээр зүйл. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг “халагдсан бол” гэснийг “чөлөөлөгдсөн бол” гэж, 18 дугаар зүйлийн 1 дахь хэсгийн “халагдах тохиолдолд” гэснийг “чөлөөлөгдсөн тохиолдолд” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 17¹ дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Энэ тохиолдолд уг эхийн зөвхөн хоёр удаагийн төрөлт хамаарна.” гэснийг хассугай.

6 дугаар зүйл. Энэ хуулийг 2022 оны ... дүгээр сарын ... -ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН
ТАНДАН СУДЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Улаанбаатар хот

ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль нь 1994 онд батлагдсан ба зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, тагнуул, төрийн тусгай хамгаалалт, цагдаа, шүүхийн шинжилгээний болон авлигатай тэмцэх, онцгой байдлын асуудал эрхэлсэн болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын генерал, офицер, ахлагч, түрүүч, байлдагч, цэрэг, цагдаагийн сургуулийн сонсогч /энэ хуульд цаашид "цэргийн алба хаагч" гэх/ нарт тэтгэвэр, тэтгэмж тогтоож, олгохтой холбоотой олон салбарын алба хаагчдын нийгмийн хамгаалал, эрх зүйн байдалтай холбогдох харилцааг зохицуулах хууль болохын хувьд цаг үеийн шаардлагаар нийт 23 удаа нэмэлт, өөрчлөлт орсон байна.

Монгол Улсын Их Хурал нь бүрэн эрхийнхээ хүрээнд буюу Батлан хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1-д "батлан хамгаалах бодлого, тогтолцооны эрх зүйн үндсийг тогтоох" гэж, мөн хуулийн "11.1.3.цэргийн алба хаагчийн нийгмийн хамгаалал, эрх зүйн байдлыг албаны онцлогт нь тохируулж тогтоох" гэсэн эрх зүйн зохицуулалтын дагуу 2017 онд Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, Монгол Улсын Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн болон энэ хуулийн үйлчлэлд хамаардаг байгууллагуудын алба хаагч нарын алба хаах нөхцөл бололцоо, нийгмийн баталгаа, тэтгэвэр, тэтгэмжтэй холбогдох харилцааг боловсронгуй болгоход анхааран ажиллаж ирсэн.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн 12 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"-д батлан хамгаалах чиглэлээр Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар тусгаж, цэргийн тэтгэвэр тогтоолгосон иргэн Ахмад настны тухай хуульд заасан нийгмийн баталгаагаар хангагдаж нас барсан тохиолдолд түүний ар гэрт оршуулгын тэтгэмж олгохтой холбоотой эрх зүйн зохицуулалтыг тусгахаар заасан.

Мөн Улсын Их Хурлын Хүний Эрхийн дэд хорооны 2021 оны 02 дугаар тогтоолоор цэргийн албаны үйл ажиллагаанд баримталдаг салбарын хууль тогтоомжуудад хяналт шинжилгээ, хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх талаар заасны дагуу Батлан хамгаалах яам нь Хууль зүйн Үндэсний хүрээлэнтэй гэрээг байгуулж, Батлан хамгаалах тухай, Зэвсэгт хүчний тухай, Цэргийн албаны тухай, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиудад хяналт шинжилгээ, хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийлгэж холбогдох тайлан хүлээн аваад байна.

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээгээр практик амьдралд тулгарч байгаа зарим асуудлыг хууль тогтоомжид өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх талаар холбогдох дүгнэлтийг гаргажээ.

Өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөж байгаа Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн үйлчлэх хүрээнд нийт 10 байгууллагын алба хаагч нар

хамаарч байна. Цэргийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5¹, 11 дүгээр зүйлийн 11.4², 11.5³ дэх хэсэгт заасан алба хаах зохицуулалттай холбоотойгоор цэргийн алба хаагч нь Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгох эрх зүйн үндэслэл бүрдэх ба хуулийн хэрэгжилтийн талаар дун шинжилгээ хийж, холбогдох байгууллагаас санал авахад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах чиглэлээр дараах агуулга бүхий саналыг нийтлэг ирүүлж байна.

Тухайлбал, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт “Цэргийн алба хаагч, түүнчлэн дайчилгаатай сургууль цугларалтад оролцож байгаа цэргийн үүрэгтэн нас бараад түүний оршуулгад зориулан нас барагчийн ар гэрт олгох тэтгэмж олгоно.” гэж заасан ба харин цэргийн тэтгэвэр тогтоолгосон хэдий ч Ахмад настны тухай хуулийн үйлчлэлд хамаардаггүй цэргийн тэтгэвэр авагч нас барсан тохиолдолд оршуулгын тэтгэмжийг хэрхэн олгох асуудал эрх зүйн зохицуулалтгүй байна.

Мөн эмэгтэй алба хаагч ахлагч болон офицерын албыг цэргийн цол харгалзахгүйгээр 47 нас хүртэл хаахаар Цэргийн албаны тухай хуульд нийтлэг байдлаар хуульчилсантай холбогдуулан эмэгтэй цэргийн алба хаагчийн хувьд жирэмсэний болон хүүхэд асрах чөлөөтэй байсан хугацааг цэргийн алба хаасан хугацаанд оруулан тооцох талаар эрх зүйн зохицуулалт хангалтгүй байгааг хуульд нарийвчлан тусгах хэрэгцээ шаардлага байгаа болно.

АЦэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 19 дүгээр

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Цэргийн алба хаагч орон тоо, зохион байгуулалтын өөрчлөлт, биеийн эрүүл мэндээр, түүнчлэн цэргийн алба хаах нас хэтэрч халагдвал түүнд 18 сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний тэтгэмжийг нэг удаа олгоно.” гэсэн эрх зүйн зохицуулалтыг тус хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэгтэй уялдуулан өөрчлөж, хуулийг нэг мөр ойлгож, хэрэглэх боломжийг бүрдүүлэх хэрэгцээ, шаардлага үүсээд байна.

Иймд Улсын Их хурлын 2015 оны 85 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс баримт бичгийн 5.6-д “Цэргийн алба хаагч, цэргийн анги, байгууллагад гэрээгээр ажиллагсдын алба хаах нөхцөлийг бүрдүүлэх, нийгмийн баталгааг хангах эрх зүйн орчныг боловсронгуй болгоно”, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.6.9-д “Цэргийн хугацаат болон гэрээт алба хаагчдын алба хаах хугацаанд амьдрах, ажиллах нөхцөлийг сайжруулна.” гэж заасан зорилтын хүрээнд Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар илүү боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлага байна гэж үзсэн.

Практик шаардлагын хувьд Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль нь 1994 онд батлагдсан ба хуулийн зорилт нь Зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, тагнуул, төрийн тусгай хамгаалалт, цагдаа, шүүхийн шинжилгээний болон авлигатай тэмцэх, онцгой байдлын асуудал эрхэлсэн болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын генерал, офицер, ахлагч, түрүүч,

¹ 10.5. Иргэн ахлагчийн албыг 47 нас хүртэл хаана.

² 11.4. Офицерын албыг дунд офицер 47 нас хүртэл, ахлах офицер 52 нас хүртэл, дээд офицер 57 нас хүртэл хаана.

³ 11.5. Эмэгтэйчүүд офицерын албыг цэргийн цол харгалзахгүйгээр 47 нас хүртэл хаана.

байлдагч, цэрэг, цагдаагийн сургуулийн сонсогч /энэ хуульд цаашид "цэргийн алба хаагч" гэх/ нарт тэтгэвэр, тэтгэмж тогтоож, олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад чиглэсэн ба цаг үеийн шаардлагаар нийт 23 удаа нэмэлт, өөрчлөлт оруулжээ.

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуультай холбогдуулан хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах дараах практик хэрэгцээ шаардлага байна. Тухайлбал:

1. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт "Цэргийн алба хаагч, түүнчлэн дайчилгаатай сургууль цугларалтад оролцож байгаа цэргийн үүрэгтэн нас барахад түүний оршуулгад зориулан нас барагчийн ар гэрт олгох тэтгэмж олгоно." гэж заасан.

Тус зохицуулалт нь хугацаат болон гэрээт, ахлагч, офицерын албыг хааж буй цэргийн алба хаагч болон дайчилгаатай сургууль цугларалтад оролцож байгаа цэргийн бэлтгэл үүрэгтэнд хамаарал бүхий зохицуулалт ба харин цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгосон иргэнд үйлчлэхгүй байгаагаас шалтгаалан цэргийн тэтгэвэр тогтоолгосон алба хаагч нас барсан тохиолдолд оршуулгын зардлыг төрөөс олгохгүй байгаа байдлыг өөрчлөн нийгмийн хамгаалал, баталгааг сайжруулах шаардлага байна.

2. Цэргийн албаны тухай хуульд зааснаар алба хаагч нь дунджаар 47-57 насын хооронд цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгож байгаа ба эмэгтэй цэргийн алба хаагч нь цол харгалзахгүйгээр 47 нас хүртэл, түүнчлэн Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-т "20-оос доoshгүй жил алба хаасан эмэгтэй" нас харгалзахгүйгээр цэргийн алба хаасны тэтгэвэр, тогтоолгох эрхтэй гэж заасан байна.

Эмэгтэй цэргийн алба хаагчийн хувьд жирэмсний болон хүүхэд асрах үеийн чөлөөтэй байсан хугацаа нь ажилласан жилд хамаарах талаарх эрх зүйн зохицуулалт дутмаг байгаагаас улбаалан цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгох үед ажилласан жил хүрэхгүй байх тохиолдол гарч байх тул холбогдох эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан хуульд тусгах шаардлагатай байна.

3. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Цэргийн алба хаагч орон тоо, зохион байгуулалтын өөрчлөлт, биеийн эрүүл мэндээр, түүнчлэн цэргийн алба хаах нас хэтэрч халагдвал түүнд 18 сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний тэтгэмжийг нэг удаа олгоно." гэж заасан нь алба хаагч нь цэргийн албанаас халагдсан тохиолдолд алба хаасан хугацаанаас үл хамаарч 18 сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний тэтгэмжийг авах эрх үүсэхээр байгааг анхаарч, хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэгтэй уялдуулан өөрчлөх шаардлага байгаа болно.

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар алба хаагчдыг эрх зүй, нийгмийн баталгааг сайжруулж, хууль тогтоомжийг нэг мөр ойлгож хэрэглэх боломж нэмэгдэх зэрэг олон давуу тал бий болох юм.

Иймд дээр дурдсан тулгамдсан асуудлыг шийдвэрлэхийн тулд Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5.1-д заасны дагуу Цэргийн алба

хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын /цаашид Аргачлал гэх/ 1.3-т заасан хүрээнд хамаarahгүй тул урьдчилан тандан судлах ажиллагааг Аргачлалын 2.1-т заасан үе шатны дагуу хийж гүйцэтгэлээ.

НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль нь 1994 онд батлагдсан ба зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, тагнуул, төрийн тусгай хамгаалалт, цагдаа, шүүхийн шинжилгээний болон авлигатай тэмцэх, онцгой байдлын асуудал эрхэлсэн болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын генерал, офицер, ахлагч, түрүүч, байлдагч, цэрэг, цагдаагийн сургуулийн сонсогч /энэ хуульд цаашид "цэргийн алба хаагч" гэх/ нарт тэтгэвэр, тэтгэмж тогтоож, олгохтой холбоотой олон салбарын алба хаагчдын нийгмийн хамгаалал, эрх зүйн байдалтай холбогдох харилцааг нийтлэг байдаар зохицуулж байна.

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, алба хаагчдын эрх зүйн байдал, нийгмийн баталгааг бүрдүүлэх чиглэлээр харьяа агентлаг болох Зэвсэгт хүчний Жанжин штаб, аж ахуйн нэгж, байгууллагаас санал авахад алба хаагчдын нийгмийн баталгааг бүрдүүлэх чиглэлээр холбогдох саналыг ирүүлсэн. Тухайлбал, цэргийн тэтгэвэр авагч нас барсан тохиолдолд оршуулгын тэтгэмж олгох, эмэгтэй цэргийн алба хаагчийн жирэмсний болон хүүхэд асрах чөлөөтэй байсан хугацааг алба хаасан хугацаанд оруулах тооцох зэрэг асуудал эрх зүйн зохицуулалтгүй хэрэгжиж байгааг анхаарч, холбогдох зохицуулалтыг хуульчлах зэрэг болно.

УИХ-ын 2015 оны 85 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс" баримт бичиг баталсан ба 5.6 дахь хэсэгт "Цэргийн алба хаагч, цэргийн анги, байгууллагад гэрээгээр ажиллагсдын алба хаах нөхцөлийг бүрдүүлэх, нийгмийн баталгааг хангах эрх зүйн орчныг боловсронгуй болгоно" гэж заасан ба цэргийн алба хаагчийн эдлэх эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хуулиар хязгаарлагдмал байдагтай холбогдуулан алба хаагчийн эрх зүйн баталгааг хуулиар оновчтой тодорхойлох зүйтэй юм.

Иймд Аргачлалын 3-т заасны дагуу асуудалд дүн шинжилгээ хийхдээ асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх гэж байгаа асуудлын мөн чанар, цар хүрээг тогтоож, тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдэж байгаа нийгмийн бүлэг, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг оновчтой тогтоож, улмаар түүнийг үүсгэж байгаа шалтгаан, нөхцөлийг тодорхойлооор зорилоо.

1.1. Асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсон байдал:

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар цэргийн тэтгэвэр авагч нас барсан тохиолдолд оршуулгын зардал олгодог байх, эмэгтэй цэргийн алба хаагчийн жирэмсний болон хүүхэд

асрах чөлөөтэй байсан хугацааг алба хаасан хугацаанд оруулан тооцох, алба хаагч хувь тэнцүүлэн тэтгэвэр тогтоолгоход 18 сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмжийг олгох шалгуур нөхцөлийг нарийвчлан тогтоох, хуулийг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэхтэй холбогдох аргачлалын эрх зүйн үндэслэлийг хуульчлах зэрэг хэрэгцээ, шаардлага байна.

Эрх зүйн зохицуулалт:

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улс өөрийгөө хамгаалах зэвсэгт хүчинтэй байна. Зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалт, түүнд алба хаах журмыг хуулиар тогтооно.” гэж;

Мөн Улсын Их Хурлын 2015 оны 85 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичигт 5.6 дахь хэсэгт “Цэргийн алба хаагч, цэргийн анги, байгууллагад гэрээгээр ажиллагсдын алба хаах нөхцөлийг бүрдүүлэх, нийгмийн баталгааг хангах эрх зүйн орчныг боловсронгуй болгоно” гэж,

Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3-т “Цэргийн алба хаагчийн нийгмийн хамгаалал, эрх зүйн байдлыг албаны онцлогт нь тохируулж тогтоох” гэж тус тус заасантай нийцүүлэн Цэргийн алба тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах эрх зүйн хэрэгцээ, шаардлага тодорхойлогдож байна.

Практик хэрэгжилтийн байдал:

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуультай холбогдуулан хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах дараах практик хэрэгцээ шаардлага байна. Тухайлбал:

1. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт “Цэргийн алба хаагч, түүнчлэн дайчилгаатай сургууль цугларалтад оролцож байгаа цэргийн үүрэгтэн нас барагад түүний оршуулгад зориулан нас барагчийн ар гэрт олгох тэтгэмж олгоно.” гэж заасан.

Тус зохицуулалт нь хугацаат болон гэрээт, ахлагч, офицерын албыг хааж буй цэргийн алба хаагч болон дайчилгаатай сургууль цугларалтад оролцож байгаа цэргийн бэлтгэл үүрэгтэнд хамаарал бүхий зохицуулалт ба харин цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгосон иргэнд үйлчлэхгүй юм.

Энэхүү нөхцөл байдлаас шалтгаалан цэргийн тэтгэвэр тогтоолгосон алба хаагч нас барсан тохиолдолд оршуулгын зардлыг түүний ар гэрт олгохгүй байгаа юм. Иймд холбогдох эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан тодорхойлох хэрэгцээ, шаардлага байна.

2. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Шимтгэл төлсөн нийт хугацааг тодорхойлохдоо тэтгэврийн болон тэтгэмжийн даатгалын шимтгэлийг ажил олгогчоос болон даатгуулагч өөрөө төлсөн нийт хугацааны дээр шимтгэл төлсөн хугацаанд оруулан тооцооюуд заасан байдаг тул энгийн албан хаагч, даатгуулагч эмэгтэйд жирэмсэний болон хүүхэс асрах хугацаа нь ажилласан жил тасалдах нөхцөл үүсдэггүй байна.

Харин Цэргийн албаны тухай болон Цагдаагийн албаны тухай хуулиудад зааснаар эмэгтэй алба хаагчийн хувьд жирэмсний болон хүүхэд асрах чөлөөтэй байх хугацаа нь цэргийн алба хаах хугацаанд хамаарах талаарх эрх зүйн зохицуулалт дутмаг байгаагаас улбаалан цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгох үед ажилласан жил хүрэхгүй байх тохиолдол гарч байна. Тухайлбал: 2020 оны байдлаар Зэвсэгт хүчний хэмжээнд нийт 225 алба хаагч жирэмсний болон амаржсаны чөлөөтэй байгаа ба жирэмсний болон хүүхэд асрах чөлөөтэй байх хугацааг цэргийн алба хаасан хугацаанд оруулах тооцохгүй байгааг анхаарч, холбогдох зохицуулалтыг хуульд тусгаснаар эмэгтэй алба хаагч нарын нийгмийн баталгаа сайжран гэж үзэж байна.

3. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Цэргийн алба хаагч орон тоо, зохион байгуулалтын өөрчлөлт, биеийн эрүүл мэндээр, түүнчлэн цэргийн алба хаах нас хэтэрч халагдвал түүнд 18 сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний тэтгэмжийг нэг удаа олгоно.” гэж заасан.

Дээр дурдсан хуулийн зохицуулалтын хүрээнд алба хаагч нь цэргийн албанаас халагдсан тохиолдолд алба хаасан хугацаанаас үл хамааран 18 сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний тэтгэмжийг авах эрх үүсэхээр байгаа нь зарим тохиолдолд эрүүл мэндийн гэх шалтгаанаар цэргийн албанаас хугацаанаас өмнө чөлөөлөгдөх, улмаар 18 сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний тэтгэмжийг авах боломжийг бүрдүүлж байгааг анхаарч, эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан хуульчлах шаардлага тулгамдаж байна.

4. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг нэг мөр ойлгож, хэрэглэх асуудлын хүрээнд Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн зарим зохицуулалтыг хэрэгжүүлэх аргачлалыг Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн даргын 2014 оны 07 дүгээр сарын 22-ны өдрийн А/58, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын А/105 дугаар хамтарсан тушаалаар баталсан байdag.

Тус аргачлал нь Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн зарим зохицуулалтыг хэрхэн ойлгож, хэрэглэх талаар гарын авлага болдог төдийгүй уг гарын авлагыг батлан мөрдүүлэхтэй холбогдох эрх зүйн үндэслэлийг хуульчлан баталгаажуулах хэрэгцээ шаардлагатай байгаа болно.

Иймд дээр дурдсан тулгамдсан асуудлыг шийдвэрлэхийн тулд Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5.1-д заасны дагуу Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

1.2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээд:

Дээрх нөхцөл байдлаас дүгнэж үзвэл холбогдох зохицуулалтыг Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд тусгахгүй байх нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс баримт бичигт заасан цэргийн алба хаагчийн хууль ёсны эрх ашигт сөргөөр нөлөөлж байна гэж үзэх үндэстэй байна.

Эрх ашиг нь хөндөгдөх бүлэг		Нөлөөлж буй хэлбэр
1	Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 1 дүгээр зүйлд заасан байгууллагын алба хаагч нар	- Цэргийн тэтгэвэр тогтоолгосон иргэн нас барсан тохиолдолд түүний ар гэрт оршуулгын зардал олгох талаар эрх зүйн зохицуулалтгүй, эмэгтэй цэргийн алба хаагчийн жирэмсний болон хүүхэд асрах чөлөөтэй байгаа хугацааг цэргийн алба хаасан хугацаанд оруулан тооцох талаар нэгдсэн ойлголт хомс, цэргийн алба хаагчийн 18 сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмжийг олгох шалгуур нөхцөлийг нарийвчлан тогтоох, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэхтэй холбогдох аргачлалыг батлах эрх зүйн үндэслэлийг хуульчлах зэрэг асуудал зэрэг болно.

1.3. Асуудлыг үүсгэж буй учир шалтгаан:

Холбогдох нөхцөл байдлыг судлан үзвэл Цэргийн алба тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд дараах зохицуулалтыг нарийвчлан тодорхойлох шаардлагатай байна. Эдгээрийг багцлан үзвэл:

- Цэргийн тэтгэвэр тогтоолгосон иргэн нас барсан тохиолдолд түүний ар гэрт оршуулгын зардал олгохтой холбогдох харилцааг хуульчлах;

- Эмэгтэй цэргийн алба хаагчийн жирэмсний болон хүүхэд асрах чөлөөтэй байсан хугацааг цэргийн алба хаасан хугацаанд оруулан тооцохтой холбогдох асуудлыг хуульчлан баталгаажуулаах;

- Цэргийн алба хаагчид 18 сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмжийг олгох шалгуур нөхцөлийг нарийвчлан тогтоох,

- Монгол Улсын Их Хурлын Хүний эрхийн дэд хорооны 2021 оны 02 дугаар тогтоолтой уялдуулан Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хууль зүйн судалгааны төвөөр судалгаа хийлгүүлж, гарсан саналыг хуульд тусгах юм.

- Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэхтэй холбогдох аргачлалыг батлах эрх зүйн үндэслэлийг хуульчлах зэрэг асуудлыг Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх юм.

**ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ
ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ**

Эрх зүйн зохицуулалтын хувьд Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж холбогдох эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан тогтоох асуудал тулгамдаж байна.

Иймд Аргачлалын 4-т заасны дагуу асуудлыг шийдвэрлэх зорилтыг дараах байдлаар тодорхойлж байна.

Зорилт: “Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар цэргийн алба хаагчийн үүрэг гүйцэтгэх нөхцөл, хуулийн тэгш, шудрага байх зарчмыг ханган, эрх зүйн баталгааг нарийвчлан тогтоох”

**ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН
ЭЕРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ**

Асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг тогтоож, Аргачлалын 5-д заасны дагуу зорилгод хүрэх байдал буюу “Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар цэргийн алба хаагчийн үүрэг гүйцэтгэх нөхцөл, эрх зүйн баталгааг нарийвчлан тогтоох” зорилтыг хангаж чадах эсэх, зардал, үр өгөөжийн харьцаа буюу хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардал, үзүүлэх зэрэг өөрчлөлтийг харьцуулан судалж дараах дүгнэлтийг гаргалаа.

Хувилбар		Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
1	Тэг хувилбар	Шийдвэрлэвэл зохих асуудал хэвээр үргэлжлэх бөгөөд тодорхой үр дүн хүрэх боломжгүй.	Нэмэлт зардал гарагчгүй ч, асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөлийг шийдвэрлэж чадахгүй.	Үр дүн сөрөг
2	Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх	Хэвлэл, мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль тогтоомжийн талаар олон нийтийг соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах нь хууль тогтоомжийн талаар иргэд олон нийтийн ойлголтыг батжуулах хэдий ч асуудлыг шийдвэрлэх боломжгүй.	Хэвлэл, мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль тогтоомжийн талаар олон нийтийг соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах, хууль тогтоомжийг иргэдэд сурталчлан таниулахтай холбоотойгоор төсвөөс зардал гарах хэдий ч асуудлыг бүрэн шийдвэрлэх боломжгүй.	Үр дүн сөрөг
3	Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх	Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуультай хамаарал бүхий асуудлыг зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийснээр үр дүнд хүрэх боломжгүй.	Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийснээр үр дүнд хүрэхгүй.	Үр дүн сөрөг
4	Төрөөс санхүүгийн интервенц хийх	Төрөөс санхүүгийн интервенц хийх нь цэргийн алба хаагчийн үүрэг гүйцэтгэх нөхцөл, эрх зүйн баталгааг бүрдүүлэхэд чухал нөлөө	Төрөөс санхүүгийн интервенц хийснээр цэргийн алба хаагчтай холбоотой хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх боломжтой хэдий ч эрх	Үр дүн сөрөг

		үзүүлэх хэдий ч асуудлыг бүрэн шийдвэрлэхэд үр дүн муутай байна.	зүйн зохицуулалтыг бий болгохгүйгээр зохих үр дүнд хүрэхгүй юм.	
5	Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх	Монгол Улсын Үндсэн хуулийн 11 дүгээр зүйлийн 1-д “Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн.” гэж заасан ба уг үүргийг төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх боломжгүй юм.	Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар “Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн.” гэж заасан ба уг үүргийг төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх боломжгүй юм.	Үр дүн сөрөг
6	Захиргааны шийдвэр гаргах	Хамрагдах хүрээ, оролцогч талуудын хариуцлагыг нэмэгдүүлэх, хяналт сайжрах боломж бүрдэх боловч үр дүнд төдийлөн ахиц гаргаж чадахгүй.	Захиргааны акт гаргах замаар цэргийн алба хаагчийн үүрэг гүйцэтгэх нөхцөл, эрх зүйн баталгаатай холбоотой харилцааг зохицуулах нь тодорхой үр дүнд хүрч болох хэдий ч тухайн харилцааг бүрэн зохицуулах боломжгүй ба захиргааны зардал өндөр, төрийн байгууллага, иргэн хуулийн этгээдийн уялдаа холбоог сайжруулах үр дүнтэй зохицуулалт болж чадахгүй байна.	Тодорхой үр дүнд хүрнэ.
7	Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах	Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар цэргийн алба хаагчийн эрх зүй, нийгмийн баталгааг сайжруулах боломж нэмэгдэнэ.	Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар алба хаагчийн эрх зүй, нийгмийн баталгааг бэхжүүлэх, хуулийг зөвөөр ойлгож, хэрэглэх боломж нэмэгдэх юм.	Үр дүнтэй

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар энэ хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын алба хаагчийн үүрэг гүйцэтгэх нөхцөл, эрх зүйн баталгаа нэмэгдэх ба тухайн байгууллагын төсвийн зардал тодорхой хэмжээгээр нэмэгдэх юм. Харьцуулалтын үр дүнг харгалзан үзвэл дараах 2 хувилбар илүү эерэг нөлөөтэй байх магадлалтай байна:

- Хувилбар-1: Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжтэй холбогдох зарим харилцааг захиргааны актаар зохицуулах;
- Хувилбар-2: Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжтэй холбогдох зарим харилцааг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар зохицуулах.

Иймд тухайн хуулийн төслийн агуулга, зохицуулалтын хэлбэрийг дараах байдлаар ерөнхийлөн томьёолж байна. Үүнд:

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар цэргийн тэтгэвэр тогтоолгосон иргэн нас барсан тохиолдолд түүний ар гэрт оршуулгын зардал олгох, эмэгтэй алба хаагчийн жирэмсний болон хүүхэд асрах чөлөөтэй байгаа хугацааг алба хаасан жилд оруулан тооцох, цэргийн алба хаагчийн 18 сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмжийг олгох шалгуур нөхцөлийг нарийвчлан тогтоох, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэхтэй холбогдох аргачлалыг батлах эрх зүйн үндэслэл бүрдэх юм.

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Аргачлалын 6-д заасны дагуу сонгосон 2 хувилбарын үр нөлөөг аргачлалд заасны дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа.

4.1.Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Хувилбар 1, 2-ын хүрээнд Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар алба хаагчийн үүрэг гүйцэтгэх, нөхцөл эрх зүйн баталгааг хуульчлан баталгаажуулахад чиглэж байна.

Иймд дээр дурдсан асуудлыг шийдвэрлэхийн тулд Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах нь үр дүнтэй хувилбар гэж үзэж байна.

4.2.Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Сонгосон хувилбарын аль аль нь төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын алба хаагчийн эрх зүйн баталгааг бүрдүүлэхэд чиглэж байна.

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагын тухайн жилийн төсөөт бага хэмжээний нэмэлт зардал үүсэх боловч гарах зардлыг хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцооны судалгаанд дэлгэрэнгүй тусгана.

4.3.Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Сонгосон хоёр хувилбарын хувьд аль аль нь зорилтоо биелүүлэхэд эергээр нөлөөлнө.

Хувилбар 2-ыг хэрэгжүүлэх нь цэргийн алба хаагчийн эрх зүйн баталгаа, нийгмийн хамгааллын чиглэлээр тулгамдаж байгаа зарим асуудлыг шийдвэрлэх, илүү үр дүнтэй хувилбар байх магадлалтай байна. Харин хувилбар 1-ийг хэрэгжүүлэх нь асуудлыг цогцоор нь шийдвэрлэж чадахгүй тул оновчгүй гэж үзлээ..

4.4.Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Хувилбарууд бүгд байгаль орчинд ямар нэгэн шууд болон шууд бус сөрөг нөлөө үзүүлэхгүй.

4.5. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улс өөрийгөө хамгаалах зэвсэгт хүчинтэй байна. Зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалт, түүнд алба хаах журмыг хуулиар тогтооно.” гэж заасан байна.

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар “Цэргийн алба хаагчийн ажиллах нөхцөл, эрх зүйн баталгаа сайжирч, ажил үүргээ хэвийн гүйцэтгэхэд чухал нөлөө үзүүлнэ.

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах нь Монгол Улсын Үндсэн хууль болон хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээнд нийцэх бөгөөд хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжтой аливаа хэлбэрээ зөрчилдөхгүй болно.

ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ

Аргачлалын 7-д зааснаар хувилбаруудын эерэг болон сөрөг талуудыг

- Зорилгод хүрэх байдал;
- Зардал, үр өгөөжийн харьцаа;
- Хүний эрх, эдийн засагт, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө;
- Хууль тогтоомжтой нийцэж буй эсэх;
- Гарч болох сөрөг үр дагавар, түүнийг арилгах хувилбар байгаа эсэх гэсэн шалгуураар дахин нягтлан үзэж дараах дүгнэлтийг хийлээ.

Эрх зүйн орчныг сайжруулахын тулд хувилбар 1-ийг буюу захиргааны актыг батлан мөрдүүлж болох боловч асуудлыг цогцоор шийдвэрлэж чадахгүйд хүрэхээр байна. Өөрөөр хэлбэл Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжтэй холбогдох шийдвэрлэвэл зохих харилцааг зохицуулах эрх зүйн оновчтой шийдэл болж чадахгүй байна. Хувилбар 2 буюу Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар алба хаагчийн ажиллах нөхцөл эрх зүйн баталгаатай холбоотой асуудлыг зохицуулах боломж өндөр байна.

ЗУРГАА. ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын Их Хурлын 2015 оны 85 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичигт 5 дугаар зүйлийн 5.6-д “Цэргийн алба хаагч, цэргийн анги, байгууллагад гэрээгээр ажиллагсдын алба хаах нөхцөлийг бүрдүүлэх, нийгмийн баталгааг хангах эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.” Гэсэн Цагдаагийн албаны тухай хуулийн 83.2-т “Цагдаагийн алба хаагч нь Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу тэтгэвэр тогтоолгож, тэтгэмж авна” гэсэн эрх зүйн зохицуулалт хангагдана.

Иймд харьцуулалтын үр дүнг харгалзан үзэж тулгамдаж байгаа асуудлыг цогцоор шийдвэрлэх боломжийн хувьд 2 дахь хувилбар буюу Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг батлан хэрэгжүүлэх хувилбар илүү үр дүнтэй байна.

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж дараах асуудлыг нарийвчлан зохицуулах шаардлагатай байна. Үүнд:

- Цэргийн тэтгэвэр авагч нас барсан тохиолдолд түүний ар гэрт оршуулгын зардал олгохтой холбогдох харилцааг хуульчлах;
- Эмэгтэй цэргийн алба хаагчийн жирэмсний болон хүүхэд асрах чөлөөтэй байгаа хугацааг ажилласан жил нь оруулан тооцохтой холбогдох асуудлыг хуульчлан тогтоох;
- Цэргийн алба хаагчид 18 сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмжийг олгох шалгуур нөхцөлийг нарийвчлан тогтоох,
- Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэхтэй холбогдох аргачлалыг батлах эрх зүйн үндэслэлийг бий болгох зэрэг асуудлыг Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх боломжтой юм.

---оОо---

Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөний үнэлгээ.

ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ (Хүснэгт 1)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх	1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1. Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	Үгүй	Ялгаварлан гадуурхсан зохицуулалтыг тусгахгүй.
	1.1.2. Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Ялгаварлан гадуурхсан зохицуулалтыг тусгахгүй.
	1.1.3. Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ мөн бол олон улсын болон үндэсний хүний эрхийн хэмжээнд нийцэж буй эсэх	Тийм	Үгүй	Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ биш.
	1.2. Оролцоог хангах			
	1.2.1. Зохицуулалтын хувилбарыг сонгоходоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм	Үгүй	Холбогдох зохицуулалтыг хуульд тусгахдаа эрх, ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа бүлгүүдтэй мэдээлэл хуваалцаж, оролцоог хангасан.
	1.2.2. Ялангуяа зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Бүлгүүдийг тусгайлан тодорхойлж, тэдэнд үзүүлэх үр нөлөөг тооцсон.
	1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага			
	1.3.1. Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм	Үгүй	Хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах боломж нэмэгдэнэ.
	1.3.2. Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Шударга, тэгш эрх, үр өгөөжтэй байх нөхцөл, боломжийг бүрдүүлэхэд чиглүүлсэн.
	1.3.3. Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм	Үгүй	Хариуцлагатай холбоотой зохицуулалт тусгахгүй.
2. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт	2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны зорилгод	Тийм	Үгүй	Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгахгүй.

агулсан эсэх	нийцсэн эсэх			
	2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Тийм	Үгүй	Цэргийн дүрэм хувцас, ялгах тэмдгийн хэрэглээтэй холбоотой зарим хязгаарлалт хуулиар тогтооно.
3. Эрх агуулагч	3.1. Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	- Монгол Улсын Их Хурал - Монгол Улсын Засгийн газар
	3.2. Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон зохицуулалт байхгүй.
	3.3. Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалzan үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм	Үгүй	Эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзсэн үзсэн зохицуулалт агуулаагүй.
	3.4. Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх /хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй/	Тийм	Үгүй	Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг агуулаагүй.
4. Үүрэг хүлээгч	4.1. Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Төрийн байгууллага, иргэн үүрэг хүлээнэ.
5. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1. Жендерийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм	Үгүй	Жендерийн үзэл баримтлалтыг зохицуулалт агуулгаагүй.
	5.2. Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Хуульд тусгах зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан нийтлэг зарчмын хүрээнд боловсруулагдана.

ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ
(Хүснэгт 2)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1. Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1. Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэхгүй.
	1.2. Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдхөхийг оролцуулан)	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3. Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	ЭСЭХ			
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөргөдлийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Зах зээлд шинээр монополыг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (ул хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх			
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нэлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нэлөө байхгүй
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нэлөө байхгүй
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нэлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нэлөө байхгүй
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нэлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нэлөө байхгүй
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нэлөө байхгүй
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нэлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нэлөө байхгүй
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нэлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нэлөө байхгүй
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нэлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Улсын төсвийн зардал нэмэгдэнэ.
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болохгүй.
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нэлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Эөрэг нэлөө үзүүлнэ.
	10.2.Хөрөнгө оруулалтын нехцэлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нэлөө байхгүй
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нэлөө байхгүй
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн байдлаар зөрчилдэхгүй.

НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ
(Хүснэгт 3)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.4.Тодорхой наслын хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ажлын байранд тогтвортой ажиллах сонирхол нэмэгдэнэ.
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Алба хаагчдын үүрэг хариуцлага нэмэгдэнэ.
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Төрийн удирдлага, сайн	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	нөлөөлөх эсэх			
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Зарим төрийн байгууллагын хүлээх үүрэг, хариуцлага нэмэгдэнэ.
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Төрийн захиргааны зарим байгууллагын албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд өөрчлөлт орохгүй.
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх			
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөө үзүүлэхгүй
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

**БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ
(Хүснэгт 4)**

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	нэмэгдүүлэх эсэх			
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцдөд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхыг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

---оо---

ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ
ҮНЭЛЭХ АЖЛЫН ТАЙЛАН

Улаанбаатар хот

**ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ
ҮНЭЛЭХ АЖЛЫН ТАЙЛАН**

НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү үнэлгээний ажлын гол зорилго нь Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн үйлчлэх хүрээнд хамаарал бүхий төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын бие бүрэлдэхүүний алба хаах нөхцөл бололцоо, нийгмийн баталгааг сайжруулах, цэргийн алба хаагчийн гэр бүл, бэлтгэл болон чөлөөнд байгаа офицер, ахлагчийн хууль, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад чиглэгдэж, хуульд заасан эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоход оршиж байгаа юм.

Үнэлгээ хийхээр сонгож авсан хууль нь нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл хэлбэртэй байна.

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн /цаашид “хуулийн төсөл” гэх/ үр нөлөөг үнэлэхдээ Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”¹-д /цаашид “аргачлал” гэх/ заасны дагуу дараах үе шаттайгаар хийсэн болно. Үүнд:

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх зэрэг болно.

**ХОЁРХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ
СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ**

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан 6 шалгуур үзүүлэлтээс 5 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал
2. Практикт хэрэгжих боломж
3. Ойлгомжтой байдал
4. Зардал
5. Харилцан уялдаа зэрэг болно.

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зорилго нь үзэл баримтлалд тусгасан хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх /бүрэн илэрхийлж чадсан эсэх/, хуулийн төсөлд туссан зохицуулалт болон арга хэмжээнүүд нь хуулийн төслийн зорилго, зорилтод хүрэх боломжтой байдлаар томьёологдсон эсэхийг үнэллээ.

Энэхүү үнэлгээг хийхийн тулд хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага, хуулийн төслийн зорилго болон зорилгод хүрэхэд чиглэгдсэн, мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц арга хэмжээ, зохицуулалтыг сонгож авсан.

¹Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан

“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломжтой эсэхийг тооцож үзсэн.

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийг хуулийн төсөл нь түүний хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтай томъёологдсон эсэхийг шалгах үүднээс хамаарал бүхий этгээдүүдээс санал авах, хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах байдлаар үнэлгээг хийхээр сонголоо.

“Зардал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт нь улсын болон төсөвт байгууллагуудын тухайн жилийн төсөвт нэмэлт зардал үүсгэх эсэх, “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу тооцохоор энэхүү шалгуур үзүүлэлтийг сонгов.

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь Монгол Улсын батлан хамгаалахын багц хуулиуд болон Хууль тогтоомжийн тухай хуульд нийцсэн эсэхийг аргачлалд заасан асуултад хариулах байдлаар үнэлгээг хийхээр тооцов.

ГУРАВ.ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах болсон хууль зүйн болон практик үндэслэл, хэрэгцээ шаардлагад хуулийн төслийн зорилт, холбогдох зохицуулалтууд нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх үүднээс хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, үзэл баримтлал болон хуулийн төслийн зорилт, түүнийг хангахад чиглэсэн зохицуулалтуудыг харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийнэ.

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс баримт бичиг болон Монгол Улсын батлан хамгаалах чиглэлийн болон энэ хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын хууль тогтоомжуудад нийцүүлэн боловсруулсан байна.

Эрх зүйн зохицуулалт: Улсын Их Хурлын 2015 оны 85 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичигт 5.6 дахь хэсэгт “Цэргийн алба хаагч, цэргийн анги, байгууллагад гэрээгээр ажиллагсдын алба хаах нөхцөлийг бүрдүүлэх, нийгмийн баталгааг хангах эрх зүйн орчныг боловсронгуй болгоно” гэж, Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3-т “цэргийн алба хаагчийн нийгмийн хамгаалал, эрх зүйн байдлыг албаны онцлогт нь тохируулж тогтоох” гэж, мөн хуулийн 15 дугаар зүйлийн 15.3.4-д “батлан хамгаалахын хүний нөөцийн бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэх, цэргийн алба хаагч, түүний гэр бүл, бэлтгэл болон чөлөөнд байгаа офицер, ахлагчийн нийгмийн хамгаалал, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах” гэж, Төрийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-т “төрийн албан хаагч” гэж төрийн албан тушаалыг эрхэлж, эрх, үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс авч, ажиллах нөхцөл, баталгаагаар хангагдан ажиллаж байгаа этгээдийг” гэж тус тус заасантай нийцүүлэн Цэргийн алба тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт,

өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах эрх зүйн хэрэгцээ, шаардлага тодорхойлогдож байна.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д батлан хамгаалах чиглэлээр Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар тусгасан ба цэргийн тэтгэвэр тогтоолгосон иргэн Ахмад настны тухай хуульд заасан нийгмийн баталгаагаар хангагдаж, нас барсан тохиолдолд түүний ар гэрт оршуулгын тэтгэмж олгохтой холбоотой эрх зүйн зохицуулалтыг тусгах талаар заасан.

Улсын Их Хурлын Хүний эрхийн дэд хорооны 2021 оны 02 дугаар тогтоолоор цэргийн албаны үйл ажиллагаанд баримталдаг салбарын хууль тогтоомжуудад хяналт шинжилгээ, хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх талаар заасны дагуу Батлан хамгаалах яам нь Хууль зүйн Үндэсний хүрээлэнтэй гэрээг байгуулж, Батлан хамгаалах тухай, Зэвсэгт хүчин тухай, Цэргийн албаны тухай, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиудад хяналт шинжилгээ, хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийлгэж холбогдох тайланд Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль дахь эрх зүйн харилцааны зарим эрх зүйн зохицуулалтыг хуульд өөрчлөлт оруулах замаар боловсронгуй болгох зөвлөмжийг ирүүлсэн нь тус хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах зайлшгүй хэрэгцээ, шаардлагатайг нотолж байна.

Практик хэрэгжилтийн байдал: Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль нь 1994 онд батлагдсан ба хуулийн зорилт нь Зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, тагнуул, төрийн тусгай хамгаалалт, цагдаа, шүүхийн шинжилгээний болон авлигатай тэмцэх, онцгой байдлын асуудал эрхэлсэн болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын генерал, офицер, ахлагч, түрүүч, байлдагч, цэрэг, цагдаагийн сургуулийн сонсогч /энэ хуульд цаашид "цэргийн алба хаагч" гэх/ нарт тэтгэвэр, тэтгэмж тогтоож, олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад чиглэсэн ба цаг үеийн шаардлаганаар нийт 23 удаа нэмэлт, өөрчлөлт оруулжээ.

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуультай холбогдуулан хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах дараах практик хэрэгцээ шаардлага байна. Тухайлбал:

1. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт “Цэргийн алба хаагч, түүнчлэн дайчилгаатай сургууль цугларалтад оролцож байгаа цэргийн үүрэгтэн нас барагад түүний оршуулгад зориулан нас барагчийн ар гэрт олгох тэтгэмж олгоно.” гэж заасан.

Тус зохицуулалт нь хугацаат болон гэрээт, ахлагч, офицерын албыг хааж буй цэргийн алба хаагч болон дайчилгаатай сургууль цугларалтад оролцож байгаа цэргийн бэлтгэл үүрэгтэнд хамаарал бүхий зохицуулалт ба харин цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгосон иргэнд үйлчлэхгүй байгаагаас шалтгаалан цэргийн тэтгэвэр тогтоолгосон алба хаагч нас барсан тохиолдолд оршуулгын зардлыг төрөөс олгохгүй байгаа байдлыг өөрчлөн нийгмийн хамгаалал, баталгааг сайжруулах шаардлага байна.

2. Цэргийн албаны тухай хуульд зааснаар алба хаагч нь дунджаар 47-57 насны хооронд цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгож байгаа ба эмэгтэй цэргийн алба хаагч нь цол харгалзахгүйгээр 47 нас хүртэл, түүнчлэн Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-т “20-оос

доошгүй жил алба хаасан эмэгтэй” нас харгалзахгүйгээр цэргийн алба хаасны тэтгэвэр, тогтоолгох эрхтэй гэж заасан байна.

Эмэгтэй цэргийн алба хаагчийн хувьд жирэмсний болон хүүхэд асрах үеийн чөлөөтэй байсан хугацаа нь ажилласан жилд хамаарах талаарх эрх зүйн зохицуулалт дутмаг байгаагаас улбаалан цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгох үед ажилласан жил хүрэхгүй байх тохиолдол гарч байх тул холбогдох эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан хуульд тусгах шаардлагатай байна.

3. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Цэргийн алба хаагч орон тоо, зохион байгуулалтын өөрчлөлт, биеийн эрүүл мэндээр, түүнчлэн цэргийн алба хаах нас хэтэрч халагдвал түүнд 18 сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний тэтгэмжийг нэг удаа олгоно.” гэж заасан нь алба хаагч нь цэргийн албанаас халагдсан тохиолдолд алба хаасан хугацаанаас үл хамаарч 18 сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний тэтгэмжийг авах эрх үүсэхээр байгааг анхаарч, хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэгтэй уялдуулан өөрчлөх шаардлага байгаа болно.

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар алба хаагчдыг эрх зүй, нийгмийн баталгааг сайжруулж, хууль тогтоомжийг нэг мөр ойлгож хэрэглэх боломж нэмэгдэх зэрэг олон давуу тал бий болох юм.

Иймд дээр дурдсан тулгамdsan асуудлыг шийдвэрлэхийн тулд Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5.1-д заасны дагуу Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

Дээр дурдсан хэрэгцээ, шаардлагыг шийдвэрлэх зорилгоор Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5.2-т заасны дагуу Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

Аливаа хуулийн зохицуулалт нь хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн байх ёстой учраас хамгийн эхэнд хуулийн төслийн зорилгыг хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ шаардлага, үндэслэл болон зорилготой харьцуулан дараах байдлаар үнэлэх хэсгээ тогтоолоо.

Хуулийн төслийн хэрэгцээ шаардлага /Үндсэн зорилго, дэд зорилго/ хуулийн төслийн үзэл баримтлалаас	Хуулийн төслийн зорилго
<p>Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар:</p> <p>-Цэргийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд зааснаар цэргийн тэтгэвэр тогтоолгосон иргэн нас барсан тохиолдолд түүнд нийгмийн халамжаас оршуулгын тэтгэмжийг олгохгүй байгааг;</p> <p>-Эмэгтэй төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын алба хаагчийн</p>	<p>-Цэргийн алба хаагчийн нийгмийн хамгаалал, эрх зүйн байдлыг албаны онцлогт нь тохируулж тогтоох, Зэвсэгт хүчин, түүний бие бүрэлдэхүүний алба хаах нөхцөл бололцоо, нийгмийн баталгааг сайжруулах, цэргийн алба хаагчийн гэр бүл, бэлтгэл болон чөлөөнд байгаа офицер, ахлагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах эрх</p>

<p>жирэмсний болон хүүхэд асрах чөлөөтэй байсан хугацааг цэргийн алба хаасан хугацаанд оруулан тооцох талаар эрх зүйн зохицуулалтгүй байгааг;</p> <p>-Цэргийн алба хаагч 10-аас доош жил ажиллаад хуулийн 19 дүгээр зүйлд заасан үндэслэлээр цэргийн албанаас халагдах тохиолдолд жил хамаарахгүйгээр нэг удаагийн хувь тэнцүүлсэн тэтгэмж авахаар ойлгогдож байгааг тодорхой болгож, эрх зүйн зохицуулалтгыг нэг мөр ойлгож, хэрэглэх боломжийг бүрдүүлэх ажлын хүрээнд нэг удаагийн тэтгэмж олгохтой холбогдсон харилцааг тус хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэгтэй уялдуулан нарийвчлан тодорхойлох шаардлагатай байгааг;</p> <p>-Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг дагаж мөрдөхтэй холбогдох аргачлалыг батлан хамгаалах болон хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батлах эрх зүйн үндэслэлийг бүрдүүлэх шаардлага байгааг тус тус шийдвэрлэх боломж бүрдэх юм.</p>	<p>зүйн зохицуулалтгыг боловсронгуй болгоход оршино.</p>
--	--

“Практикт хэрэгжих боломж” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөлд шинээр туссан, өөрчлөн найруулсан зохицуулалтуудыг сонгож авлаа.

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл нь боловсруулалтын хувьд Хууль тогтоомжийн тухай хуулийн Дөрөвдүгээр бүлэг болон Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан байдал, хуулийг ойлгож хэрэглэх, хэрэгжүүлэх боломжтой байдлаар боловсруулагдсан эсэхийг шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь сонгон авлаа.

“Зардал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөлд тусгасан эрх зүйн зохицуулалт нь улсын болон төсөвт байгууллагын тухайн жилийн зардалд нэмэгдэл болох эсэхийг “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу тооцохоор сонгож авсан.

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар холбогдох хууль тогтоомжтой уялдаж байгааг шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь авч үзэхээр тооцлоо.

ДӨРӨВ.УРЬДЧИЛАН СОНГОСОН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ТООЦСОН /ҮНЭЛСЭН/ БАЙДАЛ

Өмнөх үе шатуудад хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар харуульяа.

Д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1.	Зорилгод хүрэх байдал	<p>1 дүгээр зүйл. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг нэмсүгэй:</p> <p>1/17¹ дүгээр зүйлийн 4 дэх хэсэг: “17¹.4. Цэргийн алба хаагч эмэгтэйн жирэмсний болон хүүхэд асрах чөлөөтэй байсан хугацааг цэргийн алба хаасан хугацаанд оруулан тооцно.</p> <p>2/24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг: “24.2. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг дагаж мөрдөхтэй холбогдох аргачлалыг батлан хамгаалах болон хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална.</p> <p>2 дугаар зүйл. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “цэргийн алба хаасны тэтгэвэр авагч” гэсний өмнө “Цэргийн алба хаагч,” гэж, 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Цэргийн алба хаагч, түүнчлэн дайчилгааны сургууль, цугларалтад оролцож байгаа цэргийн үүрэгтэн” гэсний дараа “цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгосон иргэн” гэж тус тус нэмсүгэй.</p> <p>3 дугаар зүйл. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:</p> <p>“19.2. Энэ хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу цэргийн алба хаасны тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоолгож авах эрхтэй цэргийн алба хаагч орон тоо, зохион байгуулалтын өөрчлөлт, биеийн эрүүл мэндээр, түүнчлэн цэргийн алба хаах нас хэтэрч халагдвал түүнд 18 сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний тэтгэмжийг нэг удаа олгоно.</p> <p>4 дүгээр зүйл. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийг “халагдсан бол” гэснийг “чөлөөлөгдсөн бол” гэж, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн “халагдах тохиолдолд” гэснийг “чөлөөлөгдсөн тохиолдолд” гэж, 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэг “халагдвал” гэснийг “чөлөөлөгдвэл” гэж тус тус өөрчилсүгэй.</p> <p>5 дугаар зүйл. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 17¹ дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Энэ тохиолдолд уг эхийн зөвхөн</p>	Хуулийн төслийн зохицуулалтад дүн шинжилгээ хийх
2.			Хуулийн төслийн зохицуулалтад дүн шинжилгээ хийх
			Хуулийн төслийн зохицуулалтад дүн шинжилгээ хийх
			Хуулийн төслийн зохицуулалтад дүн шинжилгээ хийх

		хоёр удаагийн төрөлт хамаарна.” гэснийг хүчингүй болсонд тооцсугай. 6 дугаар зүйл. Энэ хуулийг 2021 оны ... дугаар сарын ... –ын өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.	дүн шинжилгээ хийх Хуулийн төслийн зохицуулалтад дүн шинжилгээ хийх
3.	Практикт хэрэгжих боломж	Хуулийн төсөл бүхэлдээ	Практикт турших
4.	Ойлгомжтой байдал	Хуулийн төсөл бүхэлдээ	Ойлгомжтой байдлыг судлах
5.	Зардал	Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын дагуу тусад нь тооцно.	Зардлын тооцоо хийх
6.	Харилцан уялдаа	Хуулийн төсөл бүхэлдээ	Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдаар үнэллээ.

“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ: Хуулийн төслийг түүний үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон байдалтай харьцуулан үзэж, хуулийн төслийн зорилготой нийцэж байгааг тогтоохоор холбогдох зохицуулалтын эрх зүйн үр дагаврыг тодорхойлоход чиглэсэн.

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл.

1/17¹ дүгээр зүйлийн 4 дэх хэсэг:

“17¹.4. Цэргийн алба хаагч эмэгтэйн жирэмсний болон хүүхэд асрах чөлөөтэй байсан хугацааг цэргийн алба хаагчийн тэтгэвэр тогтоох хугацаанд оруулан тооцно.

Цэргийн алба хаагч эмэгтэйн жирэмсний болон хүүхэд асрах чөлөөтэй байсан хугацааг цэргийн алба хаасан хугацаанд оруулан тооцсоноор хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдсан төрийн болон хууль сахиулах байгууллагын эмэгтэй алба хаагчийн нийгмийн хамгаалал, эрх зүйн байдал дээшлэх, алба хаах итгэл нэмэгдэх, хууль ёсны эрх ашиг хамгаалагдах нөхцөл бүрдэнэ.

2/24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг:

“24.2. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг дагаж мөрдөхтэй холбогдох аргачлалыг батлан хамгаалах болон хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална.

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг дагаж мөрдөхтэй холбогдох аргачлалыг батлан хамгаалах болон хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батлах боломж

бүрдсэнээр салбар хооронд үүсэх үл ойлголцол арилах, эрх зүйн хувьд баримтлах хэм хэмжээний акт бий болох юм.

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл.

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “цэргийн алба хаасны тэтгэвэр авагч” гэсний өмнө “Цэргийн алба хаагч,” гэж, 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Цэргийн алба хаагч, түүнчлэн дайчилгааны сургууль, цугларалтад оролцож байгаа цэргийн үүрэгтэн” гэсний дараа “цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгосон иргэн” гэж тус тус нэмсүгэй.

Цэргийн хаагч өөрөө хүсвэл цэргийн алба хаасан болон даатгалын шимтгэл төлсөн хугацааг нэгтгэн тооцож Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу өндөр насны тэтгэвэр тогтоож авах эрх үүсэх, цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгосон иргэн нас барагчад түүний оршуулгад зориулан нас барагчийн ар гэрт олгох тэтгэмж олгохоор нэмж тусгасан зохицуулалт нь алба хаагч болон бэлтгэл, чөлөөнд байгаа ахмадуудын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалсан, нийгмийн хамгааллын асуудлыг сайжруулсан үр нөлөө гарна.

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйл.

3 дугаар зүйл. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:
“19.2. Энэ хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу цэргийн алба хаасны тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоолгож авах эрхтэй цэргийн алба хаагч орон тоо, зохион байгуулалтын өөрчлөлт, биеийн эрүүл мэндээр, түүнчлэн цэргийн алба хаах нас хэтэрч халагдвал түүнд 18 сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний тэтгэмжийг нэг удаа олгоно.

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйл.

4 дүгээр зүйл. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийг “халагдсан бол” гэснийг “чөлөөлөгдсөн бол” гэж, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн “халагдах тохиолдолд” гэснийг “чөлөөлөгдсөн тохиолдолд” гэж, 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэг “халагдвал” гэснийг “чөлөөлөгдвэл” гэж тус тус өөрчилсүгэй.

Хуулийн нэр томьёонд нийцүүлэхээр оруулсан өөрчлөлт нь хуулийг нэг мөр ойлгох, ижил нэр томьёогоор илэрхийлэх нөхцөлийг үүсгэж байна.

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 5 дугаар зүйл.

5 дугаар зүйл. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 17¹ дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Энэ тохиолдолд уг эхийн зөвхөн хоёр удаагийн төрөлт хамаарна.” гэснийг хүчингүй болсонд тооцсугай.

Эмэгтэй цэргийн алба хаагчийн нийгмийн хамгаалал, эрх зүйн байдал дээшлэх, алба хаах итгэл нэмэгдэх, хууль ёсны эрх ашиг хамгаалагдах нөхцөл бүрдэнэ.

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 6 дугаар зүйл.

6 дугаар зүйл. Энэ хуулийг 2021 оны ... дугаар сарын ... –ын өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Хуулийн үйлчлэх хугацаа тодорхой болох нөхцөл үүснэ.

“Практикт хэрэгжих боломжийг судлах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Хуулийн төсөлд оруулсан зохицуулалтууд нь Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний анги, байгууллагуудын өдөр тутмын үйл ажиллагаанд байнга тохиолддог, шийдвэрлэх шаардлагатай асуудлууд тул байгууллага, холбогдох этгээдүүдээс санал, хүсэлт авах замаар энэхүү шалгах хэрэгслийг хэрэглэж, хуулийн төслийн практик үр нөлөөг тооцсон болно.

“Ойлгомжтой байдлыг судлах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Хуулийн төсөл нь хэрэгжүүлэх, хэрэглэх этгээдүүдэд ойлгомжтой байдлаар томьёологдсон эсэхийг шалгах үүднээс хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг шалгахдаа Хууль тогтоомжийн тухай хуулийн дараах заалтад заасан шаардлагыг хангасан эсэхэд хариулт өгөх замаар шалгалаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага	
Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал
29.1.1. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан.
29.1.2. тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Тийм.
29.1.3. тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгаагүй.
29.1.4. тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болгох саналыг тусгаагүй.	Үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болгох саналыг тусгаагүй.

хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	
29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Шаардлага хангасан.
29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;	Шаардлага хангасан.
29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;	Шаардлага хангасан.
29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	Хуулийн төсөлтэй холбогдуулан бусад хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага байхгүй болно.
29.1.11.хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.	Шаардлага хангасан.
Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага	

30.1.1. Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томьёог хэрэглэх;	Шаардлага хангасан.
30.1.2. нэг нэр томьёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Нэг нэр томьёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлээгүй.
30.1.3. уг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Шаардлага хангасан.
30.1.4. хүч оруулсан нэр томьёо хэрэглэхгүй байх;	Шаардлага хангасан.
30.1.5. жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Шаардлага хангасан.

Зардлын тооцоо хийх гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтыг хэрэгжүүлэх, хэрэглэх явцад гарах зардлын эх үүсвэрийг улсын төсөвт ачаалал үүсгэхгүйгээр, байгууллага тухайн жилийн батлагдсан төсвийнхөө хүрээнд зохицуулалт хийж, шийдвэрлэж болох боломжтой “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу тооцоohoор сонгож авсан.

Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөө үнэлэх аргачлалд заасан дараах асуултад хариулах замаар хуулийн төслийн уялдаа холбоог бүхэлд нь шалгахыг зорилдоо.

д/д	Асуулт	Хариулт буюу дүн шинжилгээ
1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;	Шаардлага хангасан.
2	Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх;	Шаардлага хангасан.
3	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх;	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцсэн.
4	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;	Шаардлага хангасан.
5	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардаагүй.	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардаагүй.

6	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх;	Шаардлага хангасан.
7	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	Хуульд шаардлагатай зохицуулалтыг бүрэн тусгасан.
8	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;	Хуулийн төсөлд төрийн чиг үүргийг давхардуулан хуульчлаагүй.
9	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;	Шаардлага хангасан.
10	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	Татвар хураамж тогтоосон заалт байхгүй.
11	Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх;	Хуулийн төсөлд аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалт тусгагдаагүй.
12	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;	Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулаагүй.
13	Хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;	Хуулийн төсөл нь жендэрийн эрх тэгш байдлын асуудлыг хөндөөгүй.
14	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдаагүй.
15	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн зохицуулалт тусгагдаагүй.
16	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Хуулийн төсөлд хариуцлагын хэм хэмжээтэй холбоотой зохицуулалт тусгагдаагүй.

ТАВ.ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

5.1.Баримтжуулалт: Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхэд ашигласан дараах баримт бичиг, мэдээлэл, тоо баримтыг цуглуулан үр нөлөөг тооцох ажиллагааны тайланд баримтжуулж хавсаргалаа.

1. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээг шаардлагыг урьдчилан тандан судлах үнэлгээний тайлан;

2. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, түүнд нийцүүлж боловсруулсан хуулийн төслийн хувилбар;

5.2. Үнэлэлт дүгнэлт: Энэхүү үнэлгээний ажлын явцад тухай Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг судлан тогтоохдоо холбогдох байгууллагуудын саналыг бичгээр болон яамны цахим хуудсаар авах, холбогдох мэргэжлийн этгээдүүдийг оролцуулан хэлэлцүүлэг зохион байгуулах, хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжид харьцуулан дүн шинжилгээ хийх зэрэг аргыг ашигласан болно.

Хуулийн төслийн үр нөлөөг шалгуур үзүүлэлт бүрээр дараах байдлаар үнэлж дүгнэлээ.

Зорилгод хүрэх байдал гэсэн шалгуур үзүүлэлтээр:

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар цэргийн тэтгэвэр тогтоолгосон иргэн нас барсан тохиолдолд түүнд нийгмийн халамжаас оршуулгын тэтгэмж авах, Эмэгтэй цэргийн алба хаагчийн жирэмсэн болон хүүхэд асрах чөлөөтэй байх хугацааг цэргийн алба хаасан ажилласан жилд оруулан тооцох, Цэргийн алба хаагч 10-аас доош жил ажиллаад хуулийн 19 дүгээр зүйлд заасан үндэслэлээр цэргийн албанаас халагдах тохиолдолд жил хамаарахгүйгээр нэг удаагийн хувь тэнцүүлсэн тэтгэмж авахаар ойлгогдож байгааг тодорхой болгож, эрх зүйн зохицуулалтыг нэг мөр ойлгож, хэрэглэх боломжийг бүрдүүлэх ажлын хүрээнд нэг удаагийн тэтгэмж олгохтой холбогдсон харилцааг хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэгтэй уялдуулан нарийвчлан тодорхойлох, цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг дагаж мөрдөхтэй холбогдох аргачлалыг батлан хамгаалах болон хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батлах эрх зүйн үндэслэл бүрдэх зэрэг асуудлууд шийдвэрлэгдэх нөхцөл боломж бүрдэнэ.

“Практикт хэрэгжих боломжийг судлах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Ойлгомжтой байдал гэсэн шалгуур үзүүлэлтээр:

Түүнчлэн хуулийн төслийн ойлгомжтой байдлыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага хангасан эсэх, мөн Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалыг баримталсан эсэхийг судаллаа.

Дээрх байдлаар хуулийн төслийн ойлгомжтой байдлыг үнэлэхэд хуулийн төсөл нь нийтлэг байдлаараа хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагыг хангасан гэж үзлээ.

Зардал гэсэн шалгуур үзүүлэлтээр:

Зардал гэсэн шалгуур үзүүлэлтийн дагуу Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын дагуу холбогдох зардлыг

тодорхойлох боломжгүй тул тухайн жилийн төсөвтөө багтаан шийдвэрлэх боломжтой гэж үзэн энэхүү үнэлгээний тайланд дүгнэлтийг тусгаагүй болно.

Харилцан уялдаа гэсэн шалгуур үзүүлэлтээр:

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь үнэлэхийг зорьж, Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан асуултад хариулах байдлаар шалгалаа.

5.3.Зөвлөмж: Хуулийн төслөөр цэргийн тэтгэвэр тогтоолгосон иргэн нас барсан тохиолдолд түүнд оршуулгын зардал өгөх, эмэгтэй алба хаагчийн жирэмсний болон хүүхэд асрах чөлөөтэй байсан хугацааг цэргийн алба хаасан хугацаанд оруулан тооцдог болох, цэргийн алба хаагч 10-аас доош жил ажиллаад хуулийн 19 дүгээр зүйлд заасан үндэслэлээр цэргийн албанаас халагдах тохиолдолд жил хамаарахгүйгээр нэг удаагийн хувь тэнцүүлсэн тэтгэмж авахаар ойлгогдож байгааг тодорхой болгож, эрх зүйн зохицуулалтыг нэг мөр ойлгож, хэрэглэх боломжийг бүрдүүлэх ажлын хүрээнд нэг удаагийн тэтгэмж олгохтой холбогдсон харилцааг нарийвчлан тусгах, тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг дагаж мөрдөхтэй холбогдох аргачлалыг батлан хамгаалах болон хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батлах зэрэг эрх зүйн үндэс, боломж бүрдэх сайн талтай гэж үзэж байна.

---оо---

ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН
ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ЗАРДЛЫН ТООЦООНЫ
ТАЙЛАН

Улаанбаатар хот

ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал /цаашид “аргачлал” гэх/-ын дагуу тооцлоо.

Хуулийн төсөлд хийсэн зардлын тооцоог аргачлалын дагуу тооцох зорилго нь хуулийн төсөл батлагдан гарснаар иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардлын ачааллыг тооцож, цаашид гарах зардлын ачааллыг аль болох багасгах, бууруулах санал боловсруулахад энэхүү судалгааны зорилго оршино.

Тус хуулийн төсөл батлагдан хэрэгжсэнээр уг аргачлалын 1.5 дахь хэсэгт заасан иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагаас гарах зардал байгаа эсэхийг тооцоходо тухайн дэвшүүлсэн асуудлыг гүйцэтгэх үүргийнхэн ерөнхий байдлаар тогтоож, тохиолдлын тоо, давтамжийн тоо, цаг хугацааг статистик болон баримжаалж тооцох зэргээр энгийн математик тооцооны аргыг ашиглаж зардлыг тодорхойлов.

1. Иргэн, хуулийн этгээдэд үүсэх зардлыг тооцох:

Монгол Улсын Их Хурлын 2015 оны 85 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичгийн эдийн засгийн чиглэлд “Батлан хамгаалах арга хэмжээний зардлыг Монгол Улсын төсвөөс болон хуульд заасан бусад эх үүсвэрээс санхүүжүүлнэ. ... ” гэж, Батлан хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3-д “цэргийн алба хаагчийн нийгмийн хамгаалал, эрх зүйн байдлыг албаны онцлогт нь тохицуулж тогтоох” гэж тус тус заасан бөгөөд хуулийг хэрэгжүүлэх явцад гарах зардал нь Цэргийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн үйлчлэлд хамаардаг субъектүүдийн эрхпэх асуудлын хүрээний төсвийн ерөнхийлөн захирагчийн тухайн жилийн батлагдсан төсөв хамаарах юм. Өөрөөр хэлбэл, хуулийн үйлчлэлд хамаардаг байгууллагуудын чиг үүрэг, үйл ажиллагааны зохион байгуулалтын хүрээнд багтсан, хуулийн зохицуулалтад хамаарах алба хаагчдын цалин хөлс нь улсын төсвөөс санхүүждэг тул хувь хүн буюу иргэн, хуулийн этгээдэд ямар нэгэн нэмэлт зардал үүсэхгүй болно.

2. Төрийн байгууллагад үүсэх зардлыг тооцох

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцоходо хуулийн төсөлд тусгагдсан зардал гарах агуулга бүхий зохицуулалтыг тодорхойлж, аргачлалын 4.1-д заасны дагуу үе шаттайгаар тооцон судалж үзэв.

-Байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээг тодорхойлох үе шат:

Өнөөдөр тус хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын эмэгтэй алба хаагч нарын жирэмсний болон хүүхэд харах чөлөөтэй байх хугацааг тодорхойлох талаар хуульд тодорхой заагаагүй, уг хугацааг ажилласан жилийг ямар эрх зохицуулалтын хүрээнд шийдвэрлэх нь мөн нарийвчлагдан тусгагдаагүйгээс байгууллага бүр өөрийн төсөвтэй уялдуулан /ихэвчлэн цолны мөнгөөр/

ажилласан жилийг тодорхойлоходоо өөрийн төсөвт тодорхой хэмжээний зохицуулалт хийж иржээ. Тухайлбал, Зэвсэгт хүчний хэмжээнд 2020 онд жирэмсний болон хүүхэд харах чөлөөтэй байсан давхардсан тоогоор нийт 2183 эмэгтэй цэргийн алба хаагчид 326.694.339 төгрөг, 2021 онд мөн үндэслэлээр 2378 эмэгтэй цэргийн алба хаагчид 353.221.167 төгрөгийг олгож, энэ хэмжээгээр эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлж байсан байна.

Иймд энэхүү хуулийн төслөөр “Цэргийн алба хаагч эмэгтэйн жирэмсний болон амаржсаны амралттай байх хугацаа, хүүхэд асрах чөлөөтэй байх хугацааны төлбөл зохих эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг Хөдөлмөр нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хорооноос тухайн үед мөрдүүлэхээр баталсан сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцон сар бүр улсын төсвөөс хариуцан төлөх ба шимтгэл төлөлтийг тухайн алба хаагчийн анги, байгууллага нь нийгмийн даатгалын байгууллагад тайлagnana.” гэсэн эрх зүйн зохицуулалтыг шинээр нэмж оруулснаар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 420.000 төгрөгөөр тооцон эрүүл мэндийн мэндийн даатгалын нэг сард төлөх дүнг дунжаар 8400 төгрөгөөр бодож, сард 229 хүнээр тооцоход жилд төлөх мөнгөн дүн нь 23.083.200 төгрөг болж байгаа юм. /Тооцоог хавсаргав/

Ингэснээр байгууллагын төсөв болон, алба хаагчид ч цэргийн тэтгэвэр, тэтгэмж олгохтой харилцааг хэрэгжүүлэхэд ойлгомжтой, бусад энгийн албан хаагчидтай адилхан хэм хэмжээний түвшинд хүрэх ач холбогдолтой юм.

Хуулийн төслийн эрх зүйн зохицуулалтыг хэрэгжүүлэх, голлон гүйцэтгэх байгууллагад Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 1 дүгээр зүйлд заасан Зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, тагнуул, төрийн тусгай хамгаалалт, цагдаа, шүүхийн шинжилгээний болон авлигатай тэмцэх, онцгой байдал, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагууд хамаарна.

-Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох үе шат:

Хуульд өөрчлөлт оруулснаар дээр дурдсан байгууллагууд болон улсын хэмжээнд Нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн байгууллагын холбогдох албан тушаалтнууд цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмж олгохтой холбогдсон харилцааг чиг үүргийн хүрээндээ шуурхай шийдвэрлэнэ.

-Гарах зардлыг урьдчилан тооцох, зардлыг нэгтгэн тооцох үе шат:

Хуулийн төслийн зохицуулалтуудыг хэрэгжүүлэхэд гарах хүний нөөцийн зардал, материаллаг зардал болон бусад гарах зардал нь хамаарах байгууллагуудын төсөвт тусгагдсан байдаг тул урьдчилан тооцох, зардлыг нэгтгэн тооцох шаардлагагүй болно. Мөн хуулийн төсөлд тусгагдаж байгаа оршуулгын зардалтай холбогдох хөрөнгийг хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд өөрт ямар нэгэн ачаалал үзүүлэхгүйгээр шийдвэрлэх бүрэн боломжтой гэж тооцсон.


-Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах үе шат:

Хуулийн төслийг боловсруулахдаа тодорхой заагдсан эрх зүйн харилцааг Төрийн албаны тухай, Цэргийн албаны тухай, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулиудад заасан нийгмийн хамгаалал, хууль, хууль ёсны эрх ашгийг хангах арга хэмжээний хүрээнд тул хуулийн төсөлд хамаарах байгууллагуудын төсөвт нэмэлт зардал гарах зохицуулалтыг хуулийн төсөлд

агуулаагүй, харин тэтгэвэр, тэтгэмж тогтоохтой холбогдсон бусад хууль тогтоомжтой нийцүүлсэн болно.

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд холбогдох зохицуулалтыг шинээр нэмж тусгаснаар улсын төсөвт шинээр зардал бий болохгүй, хуулийн зохицуулалтад хамрах хүрээний байгууллагуудын тухайн жилийн батлагдсан төсвийн хүрээнд шийдвэрлэх боломжтой болно.

---оОо---



БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМЫН ТУХАЙ

ЦЭРТИЙН АЛБА

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ

ИП ТӨД

ЗУРГИЙН ЦМОГОТ

Холбоо барих

Статистик

Батлан хамгаалах яам

Баянзүрх дүүрэг, Энхтайвны өргөн

№: 13340 Улаанбаатар хот

Гендер зочилсон: 1347

Энэ долоо хоногт зочилсон:

Хууль тогтоомжийн тесел

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хувьнин төслийн танилцуулга, Узлэл баримтлал, хуулийн тесел, эзүүн албан хаячин тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж хөөрцөлж шаардлагыг урьдчилан тандан судлах үнэлгээний тайланд саналлаа ganzong@mod.gov.mn, 51-263308

Чадсаад өнөөдөр



БХЯ-НЫ СТРАТЕГИЙН БОДЛОГО,
ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН ДАРГА
ХУРАНДАА Ч.ГАНДИРВАА ТАНАА

**"БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ
АХМАДЫН ХОРОО"
НИЙГЭМД ҮЙЛЧИЛДЭГ
ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА**

13340 Улаанбаатар хот,
Баянзүрх дүүрэг, Дандарын гудамж 2,
Утас: (976-11) 451778, 3458
E-mail: seniordefence@gmail.com

2021.8.1 № 88
танай _____ -ны № _____ -т

Г Санаал өгөх тухай Г

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй танилцлаа.

Энэ төсөл нь өмнөх хуулийн зарим тодорхойгүй болон орхигдсон заалтыг тодотгосон нь ач холбогдолтой болжээ. Цэргийн алба хаагч 47-57 насандaa цэргийн тэтгэвэр тогтоолгож ахмад настанд тооцогдож байгаа хэдий ч Ахмад настны тухай хуулийн 3.1-д заасан насанд хүрээгүй гэдэг шалтгаанаар, мөн хуулийн 2 дугаар булэгт тусгагдсан / Ахмад настанд үзүүлэх үйлчилгээ, дэмжлэг, хүндэтгэл/-ийг эдэлж чаддаггүй юм.


Үүний нэгэн адил тэтгэвэр тогтоолгосон цэргийн албан хаагч 60 нас хүрэлгүй нас барсан тохиолдолд оршуулгын зардал төрөөс олгогдохгүй байгаа билээ. Иймд хуулийн төслийг бүрэн дэмжиж байгаа болно.

Цаашид Ахмад настны тухай "Монгол улсын хууль"-д өөрчлөлт оруулах нь зүйтэй гэж үзэж байна



ДАРГА
ЧӨЛӨӨНД БАЙГАА ХОШУУЧ ГЕНЕРАЛ *[Signature]* Д.МАГСАРЖАВ

*G. Энхбагод
Ихэвч, санаач
тусгах.
хур [Signature]
x/01*



ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБ
АХМАДЫН ХОРСОО

13340 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Энхтайваны өргөн чөлөө 51,
Утас: 9908 0030, Факс: (976) 7015 2429,
Э-майл: akhmadkhoro@gmail.com

2021.10.06 № 28
танай 2021.09.27-ны № 02/2018-т

БАТЛАН ХАМГААЛАХ ЯМНЫ
СТРАТЕГИЙН БОДЛОГО
ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН ДАРГА
ХУРАНДАА Ч.ГАНДИРВАА
ТАНАА

“Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль”-д
оруулах нэмэлт өөрчлөлтөд өгөх санал

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт
оруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах үнэлгээний тайлан, нэмэлт
өөрчлөлт оруулах төсөлтэй танилцаж, дараахь саналыг өгч байна.

Хуульд оруулж байгаа өөрчлөлтүүдийг дэмжиж байна.

Хуулийн төслөөр Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн
20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгосон иргэн”
гэж нэмж оруулсан байна. Гэтэл цэргийн алба хаасны тэтгэвэрт гарсан иргэн нас
бараад ар гэрт олгох тэтгэмжийг хаанаас олгох нь бүрхэг хэвээрээ үлдэж байх шиг
байна.

1. ХНХ-ын яамны сайдын өөрийн харьяа НДЕГ, ХХҮЕГ-ын дарга нарт 2019
оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 1/1772 тоот албан бичгээр хүргүүлсэн
зөвлөмжийн 3,14-т “Цэргийн тэтгэвэрт гарсан иргэн нас барсан тохиолдолд нийгмийн
даатгалын сангаас оршуулгын тэтгэмжийг олгохгүй” гэсэн байна.

“Цэргийн тэтгэвэр тэтгэмжийн тухай” хуулийн 5 дугаар зүйлд “Цэргийн
тэтгэвэр, тэтгэмжийг улсын төсвөөр санхүүжүүлнэ. Санхүүжилтийг нийгмийн
даатгалын санд шилжүүлэх журмыг Засгийн газар тогтооно” гэж заасан тул нийгмийн
даатгалын байгууллагаас олгодог байсан.

Энэхүү зөвлөмжид “Цэргийн алба хаагчийн хувьд албан үүрэг гүйцэтгэх
хугацаандаа зөвхөн эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлж, харин тэтгэвэр,
тэтгэмжийн даатгалын шимтгэл төлдөггүй тул нийгмийн даатгалын сангаас тэтгэмж
авах боломжгүй” гэсэн байна.

Ахмадын насанд хүрсэн цэргийн алба хаасны тэтгэвэр авагч нас барсан тохиолдолд нийгмийн даатгалын сангаас оршуулгын тэтгэмж авах эрх үүсэхгүй учраас “Ахмад настны тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8,1,4-т заасны дагуу оршуулгын тэтгэмжийг олгох нь зүйтэй гэжээ.


“Ахмад настны тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8,1,4-т “нийгмийн даатгалын хууль тогтоомжид заасан оршуулгын тэтгэмж авах эрх үүсээгүй ахмад настан нас барвал түүний оршуулгын зардалд нийгмийн даатгалын сангаас олгох оршуулгын тэтгэмжтэй тэнцүү хэмжээний тусламж олгох” гэсэн байна.

Иймийн учир цэргийн алба хаасны тэтгэвэрт гарсан ахмад настан нас барсан тохиолдолд ар гэрт нь хаанаас тэтгэмж олгох нь тодорхойгүй үлдэж байх шиг байна. Үүнийг хуулинд тодорхой тусгаж өгөхийг хүсэж байна.

2. “Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт: “Цэргийн алба хаагчийн тэтгэвэр тогтооход баримтлах сарын дундаж хөлсийг тэдний цэргийн алба хаасан сүүлийн 20 жилийн доторх дараалсан 5 жилийн цалин хөлсний нийлбэрийг 60-д ... хувааж тодорхойлно” гэсэн байдаг.

Гэтэл “Цэргийн албаны тухай” хуулийн 19 дүгээр зүйлийн 6-д “Цэргийн анги байгууллагын захирагч, дарга, түүнээс дээшхи удирдах албан тушаалд цэргийн алба хаагч ажиллах хугацаа 4 жил байх...”-аар заасан байдаг.

Сүүлийн үед удирдах албан тушаалд ажиллаж байгаа цэргийн алба хаагчийг 4 жил ажиллуулаад өөрчлөөд байгаа нь тэтгэврийн хэмжээ тогтооход нь сэргөөр нөлөөлж байгааг зохицуулах боломжийг судалж үзэхийг хүсэж байна.



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ, ХОЛБОГДОХ БАЙНГЫН ХОРООГООР “ЦЭРГИЙН
АЛБА ХААГЧИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ” ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦЭХЭД ОРОЛЦОХ
АЛБАН ТУШААЛТНЫ НЭР**

д/д	Нэр	Албан тушаал	Утас
1	Г.Сайханбаяр	Батлан хамгаалахын сайд	9410-0050
2	Д.Ганхуяг	БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга	9909-1170
3	Ч.Гандирваа	БХЯ-ны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга	9999-1256
4	С.Ганбямба	ЗХЖШ-ын 1-р орлогч дарга	9926-1912
5	Г.Энхболд	БХЯ-ны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын Хуулийн хэлтсийн дарга	9665-4413
6	Б.Батжаргал	ХНХЯ-ны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга	9101-2211

---оо---